



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ДАРГА ГОМБОЖАВЫН ЗАНДАНШАТАР  
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН  
Цэдэндамбын ЦЭРЭНПУНЦАГ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон,  
Утас: 26-40-88, Факс: 32-70-16  
E-mail: tserenpuntsagts@parliament.mn  
http://www.parliament.mn

2024 04 02 № УИХ-03/2486


танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх тухай

Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг  
Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж өгөхийг хүсье.

УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН



Ц.ЦЭРЭНПУНЦАГ

Г.ЗАНДАНШАТАР

Л.МӨНХБААТАР

С.ОДОНТУЯА

Д.ТОГТОХСҮРЭН

П.АНУЖИН

Ж.БАТЖАРГАЛ

Б.БАТТӨМӨР

Э.БАТШУГАР

Б.БАЯРСАЙХАН

Г.ГАНБОЛД

Г.ТЭМҮҮЛЭН

Д.ЦОГТБААТАР

О.ЦОГТГЭРЭЛ

Б.ЭНХ-АМГАЛАН

Н.ЭНХБОЛД

2024000010



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН**  
**Цэдэндамбын ЦЭРЭНПУНЦАГ**

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Жанжин Д Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон,  
Утас: 26-40-88, Факс: 32-70-16

E-mail: tserenpuntsagts@parliament.mn  
<http://www.parliament.mn>

2024.04.02 № УИТ-03/2481

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Хуулийн төсөл өргөн мэдүүлэх**  
**хугацааг товлох тухай**

Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр холбогдох баримт, бичгийн хамт хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлож өгөхийг хүсье.

Хавсралт <sup>3Б</sup> хуудастай.

УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН



Ц.ЦЭРЭНПУНЦАГ

2024003012

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн хуралдааны 12 дугаар тэмдэглэлд:

"2.ХЭЛЭЛЦСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн Г.Занданшатарын санаачлан боловсруулсан Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн Г.Занданшатарын санаачлан боловсруулсан Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцээд, Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хууль болон Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагад нийцсэн байна гэсэн санал, дүгнэлтийг хууль санаачлагчид хүргүүлэхээр тогтов." гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

**БАТЛАВ:**

**УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН**



**Г.ЗАНДАНШАТАР**

**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ  
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

**Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага**

Иргэн Н.Номун-Эрдэнээс “Газрыг гадаадын иргэн 100 жилээр ашиглах, эзэмшихийг цуцлах” сэдэвтэй нийтийн өргөдлийг Улсын Их Хурлын цахим системд 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр гаргасан бөгөөд уг өргөдөл 100167 иргэний дэмжлэг авсан байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39<sup>1</sup> дүгээр зүйлд заасны дагуу уг асуудлыг судлан үзэхэд дараах зөрчлүүд байна гэж үзсэн тул хууль хоорондын зөрчлийг арилгах зорилгоор Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа. Үүнд:

1.Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 5 дахь хэсэгт “Төрөөс гадаадын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүнд газрыг төлбөр, хугацаатайгаар болон хуульд заасан бусад болзол, журмаар ашиглуулж болно.” гэж заасан. Гэтэл 2013 онд баталсан Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх заалтад “газрыг 60 хүртэл жилээр гэрээний үндсэн дээр эзэмшүүлэх, ашиглуулах, уг хугацааг гэрээний анхны нөхцөлөөр нэг удаа 40 хүртэл жилээр сунгах” татварын бус хөрөнгө оруулалтын дэмжлэгийг хөрөнгө оруулагчид үзүүлж болохоор заасан байна. Түүнчлэн Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалтад “хөрөнгө оруулагч” гэж Монгол Улсад хөрөнгө оруулалт хийсэн гадаад, дотоодын хөрөнгө оруулагчийг ойлгоно гэж, 3.1.3 дахь заалтад “гадаадын хөрөнгө оруулагч” гэж Монгол Улсад хөрөнгө оруулалт хийж байгаа гадаадын хуулийн этгээд, хувь хүнийг ойлгоно гэж тус тус заасан. Үүнээс үзэхэд хөрөнгө оруулагч гадаадын хуулийн этгээд, гадаадын иргэнд газрыг гэрээний үндсэн дээр 60 хүртэл жилээр эзэмшүүлэх, ашиглуулах, уг хугацааг 40 хүртэл хүртэл жилээр сунгах, нийт 100 хүртэлх жилийн хугацаагаар эзэмшүүлж, ашиглуулах нөхцөл бүрдэж байгаа нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан гадаадын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүнд газрыг тодорхой болзол, журмын дагуу ашиглуулж болно гэсэн заалттай зөрчилдөж байна.

2.Газрын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь заалтад “гадаад улс, олон улсын байгууллага, гадаадын хуулийн этгээдэд газрыг тодорхой хугацаагаар түрээс, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээгээр ашиглуулах талаар шийдвэр гаргах асуудал нь Улсын Их Хурлын бүрэн эрхийн асуудал” гэж заасан бөгөөд мөн хуулийн 18.1.6 дахь заалтад “уг газрын зааг, ашиглах журмыг Засгийн газар тогтооно” гэж заасан байна. Түүнчлэн Газрын тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.5 дахь хэсэгт “Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид энэ хуулийн дагуу

газрыг тусгай зориулалт, хугацаа, болзолтойгоор ашиглуулах бөгөөд уг хугацааг Засгийн газар тогтооно.” гэж заасан байтал Хөрөнгө оруулалтын тухай хуулиар гадаадын хөрөнгө оруулагчид газрыг 100 хүртэлх жилээр эзэмшүүлэх, ашиглуулах асуудлыг зохицуулж байгаа нь газрыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлэх, ашиглуулахтай холбогдсон харилцааг зохицуулдаг Газрын тухай хуультай зөрчилдөж байна.

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 06 дугаар сарын 23-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хөрөнгө оруулалтын тухай хуулийн төслийн 16 дугаар зүйлийн 16.1.1 дахь заалтад “хөрөнгө оруулагчид газрыг 15-60 хүртэл жилээр гэрээний үндсэн дээр ашиглуулах, уг хугацааг гэрээний анхны нөхцөлөөр нэг удаа 40 хүртэл жилээр сунгах хөрөнгө оруулалтын татварын бус урамшууллыг үзүүлж болох”-оор тусгажээ. Энэ нь хэдийгээр “газрыг эзэмшүүлэх” асуудлыг хассан байгаа хэдий ч Газрын тухай хуулиар Улсын Их Хурал, Засгийн газрын бүрэн эрхийн хүрээнд шийдвэрлэдэг дээр дурдсан хуулийн зохицуулалттай мөн зөрчилдөж байна.

Иймээс хууль хоорондын зөрчлийг арилгах, иргэд, олон нийтийн сонгож байгуулсан төрийн эрх барих дээд байгууллагын үйл хэрэгт иргэдийн оролцоог хангах зорилгоор хуулийн төслийг боловсруулна.

**Хоёр.Хууль тогтоомжийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Хөрөнгө оруулагчид үзүүлэх татварын бус хөрөнгө оруулалтын дэмжлэгийн нэг хэлбэр болох газрыг 60 хүртэл жилээр гэрээний үндсэн дээр эзэмшүүлэх, ашиглуулах, уг хугацааг гэрээний анхны нөхцөлөөр нэг удаа 40 хүртэл жилээр сунгах зохицуулалтыг тусгасан заалтыг Хөрөнгө оруулалтын тухай хуулиас хасах өөрчлөлтийг тусгана.

**Гурав.Хууль тогтоомж батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал**

1.Монгол Улсын Үндсэн хууль болон газрыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлэх, ашиглуулахтай холбогдсон харилцааг зохицуулдаг Газрын тухай хуульд Хөрөнгө оруулалтын тухай хуулийг нийцүүлэх саналыг боловсруулснаар хууль хоорондын зөрчил арилна.

2.Улсын Их Хурлын санал авах цахим системээр иргэдийн саналаа өгөх идэвх нэмэгдэх, төрийн үйл хэрэгт иргэдийн оролцох оролцоо нэмэгдэнэ.

**Дөрөв.Хууль тогтоомжийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, шинэчлэн найруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал**

Хуулийн төслийг баталснаар хууль хоорондын зөрчил арилах тул хамт боловсруулах хуулийн төсөл байхгүй болно.

Харин Улсын Их Хурлын хэлэлцүүлгийн шатанд байгаа Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцэхэд Газрын тухай хуультай нийцүүлэх шаардлагатай байна.

---o0o---

## ТАНИЛЦУУЛГА

### *Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай*

Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 5 дахь хэсэгт “Төрөөс гадаадын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүнд газрыг төлбөр, хугацаатайгаар болон хуульд заасан бусад болзол, журмаар ашиглуулж болно.” гэж заасан. Мөн Газрын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2-т “гадаад улс, олон улсын байгууллага, гадаадын хуулийн этгээдэд газрыг тодорхой хугацаагаар түрээс, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээгээр ашиглуулах талаар шийдвэр гаргах асуудал нь Улсын Их Хурлын бүрэн эрхийн асуудал” гэж заасан бөгөөд уг газрын зааг, ашиглах журмыг Засгийн газар тогтооно гэж мөн хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.6-д гэж заасан байна. Түүнчлэн Газрын тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.5-д “Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид энэ хуулийн дагуу газрыг тусгай зориулалт, хугацаа, болзолтойгоор ашиглуулах бөгөөд уг хугацааг Засгийн газар тогтооно.” гэж заасан байдаг.

Дээрх хуулийн зохицуулалтууд нь гадаадын иргэн, хуулийн этгээдэд газрыг “ашиглуулах” асуудлыг зохицуулж байна. Гэтэл Хөрөнгө оруулалтын тухай хуулиар гадаадын хөрөнгө оруулагчид газрыг 100 хүртэлх жилээр эзэмшүүлэх, ашиглуулах асуудлыг зохицуулж байгаа нь Монгол Улсын Үндсэн хууль болон газрыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлэх, ашиглуулахтай холбогдсон харилцааг зохицуулдаг Газрын тухай хуультай тус тус зөрчилдөж байна.

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 06 дугаар сарын 23-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хөрөнгө оруулалтын тухай хуулийн төслийн 16 дугаар зүйлийн 16.1.1-д “хөрөнгө оруулагчид газрыг 15-60 хүртэл жилээр гэрээний үндсэн дээр ашиглуулах, уг хугацааг гэрээний анхны нөхцөлөөр нэг удаа 40 хүртэл жилээр сунгах хөрөнгө оруулалтын татварын бус урамшууллыг үзүүлж болно.” гэж тусгажээ. Энэ нь зохицуулалт нь мөн адил газрыг гадаадын иргэн, хуулийн этгээдэд эзэмшүүлэхдээ тодорхой хугацаа, болзол, журмын дагуу ашиглуулахаар заасан Монгол Улсын Үндсэн хууль болон Газрын тухай хуультай тус тус зөрчилдөж байна.

Түүнчлэн иргэд, олон нийтийн зүгээс энэ асуудалд анхаарал хандуулж, Улсын Их Хурлын албан ёсны цахим системээр дамжуулан саналаа илэрхийлсээр байгаа бөгөөд иргэн Н.Номун-Эрдэнээс “Газрыг гадаадын иргэн 100 жилээр ашиглах, эзэмшихийг цуцлах” сэдэвтэй нийтийн өргөдлийг Улсын Их Хурлын цахим системд 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр гаргасан бөгөөд уг өргөдлийг 100167 иргэн дэмжиж саналаа өгөөд байна.

Иймд Хөрөнгө оруулагчид үзүүлэх татварын бус хөрөнгө оруулалтын дэмжлэгийн нэг хэлбэр болох газрыг 60 хүртэл жилээр гэрээний үндсэн дээр эзэмшүүлэх, ашиглуулах, уг хугацааг гэрээний анхны нөхцөлөөр нэг удаа 40 хүртэл

жилээр сунгах зохицуулалтыг тусгасан заалтыг Хөрөнгө оруулалтын тухай хуулиас хасах өөрчлөлт бүхий хуулийн төслийг боловсрууллаа.

---o0o---

## ХУУЛИЙН ТӨСЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Хуулийн төслийг Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал, Хууль тогтоомжийн тухай хуулийн шаардлагад нийцүүлэн 2 зүйлтэй боловсруулна.

<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ</b>		
	Зүйл	Танилцуулга
1	<p style="text-align: center;"><b>2 дугаар зүйлээр</b></p> <p>Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх заалтыг хүчингүй болгох үүнтэй уялдуулан төслийн <b>1 дүгээр зүйлээр</b> мөн хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсгийн "Газрын тухай," гэснийг хасах.</p>	<p>1.Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 5 дахь хэсэгт "Төрөөс гадаадын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүнд газрыг төлбөр, хугацаатайгаар болон хуульд заасан бусад болзол, журмаар ашиглуулж болно." гэж заасан. Харин Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх заалтад "газрыг 60 хүртэл жилээр гэрээний үндсэн дээр эзэмшүүлэх, ашиглуулах, уг хугацааг гэрээний анхны нөхцөлөөр нэг удаа 40 хүртэл жилээр сунгах" татварын бус хөрөнгө оруулалтын дэмжлэгийг хөрөнгө оруулагчид үзүүлж болохоор заасан байна. Түүнчлэн мөн хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2-т "хөрөнгө оруулагч" гэж Монгол Улсад хөрөнгө оруулалт хийсэн гадаад, дотоодын хөрөнгө оруулагчийг ойлгоно гэж, 3.1.3-т "гадаадын хөрөнгө оруулагч" гэж Монгол Улсад хөрөнгө оруулалт хийж байгаа гадаадын хуулийн этгээд, хувь хүнийг ойлгоно гэж тус тус заасан. Үүнээс үзэхэд хөрөнгө оруулагч гадаадын хуулийн этгээд, гадаадын иргэнд газрыг гэрээний үндсэн дээр 60 хүртэл жилээр эзэмшүүлэх, ашиглуулах, уг хугацааг 40 хүртэл хүртэл жилээр сунгах, нийт 100 хүртэлх жилийн хугацаагаар эзэмшүүлж, ашиглуулах нөхцөл бүрдэж байгаа нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан гадаадын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүнд газрыг тодорхой болзол, журмын дагуу ашиглуулж болно гэсэн заалттай зөрчилдөж байна.</p> <p>2.Газрын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2-т "гадаад улс, олон улсын байгууллага, гадаадын хуулийн этгээдэд газрыг тодорхой хугацаагаар түрээс, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээгээр ашиглуулах талаар шийдвэр гаргах асуудал нь Улсын Их Хурлын бүрэн эрхийн асуудал" гэж заасан бөгөөд мөн хуулийн 18.1.6-д "уг газрын зааг, ашиглах журмыг Засгийн газар тогтооно" гэж заасан байна. Түүнчлэн Газрын тухай</p>

		<p>хуулийн 44 дүгээр зүйлийн 44.5-д “Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид энэ хуулийн дагуу газрыг тусгай зориулалт, хугацаа, болзолтойгоор ашиглуулах бөгөөд уг хугацааг Засгийн газар тогтооно.” гэж заасан байтал Хөрөнгө оруулалтын тухай хуулиар гадаадын хөрөнгө оруулагчид газрыг 100 хүртэлх жилээр эзэмшүүлэх, ашиглуулах асуудлыг зохицуулж байгаа нь газрыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлэх, ашиглуулахтай холбогдсон харилцааг зохицуулдаг Газрын тухай хуультай зөрчилдөж байна.</p> <p>Мөн Газрыг Монгол Улсын 18 насанд хүрсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллага Газрын тухай хуульд заасны дагуу эзэмшиж ашиглахаар заасан. Түүнчлэн Газрын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.7 дахь заалтад “газар эзэмших эрхийн гэрчилгээ” гэж энэ хуулийн дагуу Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын газар эзэмших эрхийг баталгаажуулсан баримт бичгийг ойлгоно гэж заасан. Иймээс газар эзэмших тухай асуудал нь Монгол Улсын иргэн, аж, ахуйн нэгж байгууллагад хамааралтай байна.</p>
--	--	---

Хууль санаачлагч

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсгийн "Газрын тухай", гэснийг хассугай.

**2 дугаар зүйл.** Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх заалтыг хүчингүй болсонд тооцугай.

Гарын үсэг

## **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН УРЬДЧИЛАН ТАНДАН СУДЛАХ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын дагуу Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн холбогдох зүйл, заалтад тандан судалгаа хийв.

Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал /цаашид “Аргачлал” гэх/-ын<sup>1</sup> 1.3-т заасан хүрээнд хамаарахгүй тул урьдчилан тандан судлах ажиллагааг Аргачлалын 2.1-д заасан үе шатны дагуу хийж гүйцэтгэлээ.

### **НЭГ.АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39<sup>1</sup> дүгээр зүйлийн 39<sup>1</sup>.2 дахь хэсэгт иргэд тодорхой асуудлыг шийдвэрлүүлэх талаарх саналаа Улсын Их Хурлын албан ёсны санал авах цахим хуудсаар дамжуулан гаргаж болох, 39<sup>1</sup>.2.3 дахь заалтад хуулийн төслийн талаарх саналыг 100 мянга ба түүнээс дээш иргэд дэмжсэн бол саналыг хэлэлцэхээр заасны дагуу иргэн Н.Номун-Эрдэнээс “Газрыг гадаадын иргэн 100 жилээр ашиглах, эзэмшихийг цуцлах” сэдэвтэй нийтийн өргөдлийг Улсын Их Хурлын цахим системд 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр гаргасан бөгөөд уг өргөдөл 100167 иргэний дэмжлэг авсан байна.

Иймд Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах шаардлагад үндэслэн энэхүү судалгааг хийв.

Аргачлалын 3-т заасны дагуу асуудалд дүн шинжилгээ хийхдээ асуудлыг тодорхойлж, шийдвэрлэх гэж байгаа тухайн асуудлын мөн чанар, цар хүрээг тогтоож, тухайн асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээдийг тодорхойлж, улмаар түүнийг үүсгэж байгаа шалтгаан, нөхцөлийг тодорхойлсон болно.

#### **1.1. Асуудлын хамрах хүрээг тодорхойлсон байдал:**

##### **Эрх зүйн зохицуулалтын талаар**

Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 5 дахь хэсэгт “Төрөөс гадаадын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүнд газрыг төлбөр, хугацаатайгаар болон хуульд заасан бусад болзол, журмаар ашиглуулж болно.” гэж заасан.

Харин Газрын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь заалтад “гадаад улс, олон улсын байгууллага, гадаадын хуулийн этгээдэд газрыг тодорхой хугацаагаар түрээс, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээгээр ашиглуулах талаар шийдвэр гаргах

---

<sup>1</sup>Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт

асуудал нь Улсын Их Хурлын бүрэн эрхийн асуудал” гэж заасан бөгөөд мөн хуулийн 18.1.6 дахь заалтад “уг газрын зааг, ашиглах журмыг Засгийн газар тогтооно” гэж заасан байна. Түүнчлэн Газрын тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.5 дахь хэсэгт “Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид энэ хуулийн дагуу газрыг тусгай зориулалт, хугацаа, болзолтойгоор ашиглуулах бөгөөд уг хугацааг Засгийн газар тогтооно.” гэж заасан.

Гэтэл Хөрөнгө оруулалтын тухай хуулиар гадаадын хөрөнгө оруулагчид газрыг 100 хүртэлх жилээр эзэмшүүлэх, ашиглуулах асуудлыг зохицуулж байгаа нь газрыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлэх, ашиглуулахтай холбогдсон харилцааг зохицуулдаг Газрын тухай хуультай зөрчилдөж байна.

Түүнчлэн иргэд, олон нийтийн зүгээс энэ асуудалд анхаарал хандуулж, Улсын Их Хурлын албан ёсны цахим системээр дамжуулан саналаа илэрхийлсээр байна. Уг цахим системд 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр цахим системд тавигдах өргөдлийн шаардлага хангасан иргэн Н.Номун-Эрдэнийн “Газрыг гадаадын иргэн 100 жилээр ашиглах, эзэмшихийг цуцлах” сэдэвтэй, “Хуулийн төсөл санаачлах талаар санал гаргах” ангиллаар нийтлүүлсэн хүсэлт 100167 иргэний дэмжлэг авсан байна.

Иймд хууль хоорондын зөрчлийг арилгах, иргэд, олон нийтийн сонгож байгуулсан төрийн эрх барих дээд байгууллагын үйл хэрэгт иргэдийн оролцоог хангах зорилгоор Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах шаардлагатайг харуулж байна.

## **1.2. Асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа бүлгийг тогтоох:**

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван Зургадугаар зүйлд “5.Төрөөс гадаадын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүнд газрыг төлбөр, хугацаатайгаар болон хуульд заасан бусад болзол, журмаар ашиглуулж болно.” гэж, Газрын тухай хуулийн 17 дугаар зүйлд “17.1. Улсын Их Хурал газрын харилцааны талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 17.1.2. гадаад улс, олон улсын байгууллага, гадаадын хуулийн этгээдэд газрыг тодорхой хугацаагаар түрээс, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээгээр ашиглуулах талаар шийдвэр гаргах;” гэж, мөн хуулийн 18 дугаар зүйлд “18.1. Засгийн газар газрын харилцааны талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:18.1.6. энэ хуулийн 17.1.2-т заасан газрын зааг, ашиглах журмыг тогтоох;” гэж, 44 дүгээр зүйлд “44.5. Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид энэ хуулийн дагуу газрыг тусгай зориулалт, хугацаа, болзолтойгоор ашиглуулах бөгөөд уг хугацааг Засгийн газар тогтооно.” гэж тус тус заасан тул хуулийн төслөөр дараах бүлгийн эрх ашиг хөндөгдөнө:

Хүснэгт 1

<b>№</b>	<b>Эрх ашиг нь хөндөгдөж байгаа бүлэг</b>	<b>Тэдний эрх, ашиг сонирхолд ямар байдлаар нөлөөлж байгаа байдал</b>
1	Иргэд	Монгол Улсын иргэдийн эрх, ашиг сонирхол болон гадаадын иргэн, хуулийн этгээд, аж ахуйн нэгжийн эрх ашиг хөндөгдөхөөр байна.

		Монгол Улсын иргэдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах, дэмжлэг үзүүлэхэд эерэг нөлөө үзүүлэхээр байна.
2	Хуулийн этгээд	Гадаадын хөрөнгө оруулагч, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, хуулийн этгээдийг ялгаварласан, эрх зүйн байдлыг дордуулсан үндэслэлээр Монгол Улсын олон улсын гэрээг зөрчсөн байдлаар сөрөг нөлөө үзүүлэхээр байна.
3	Төр, төрийн албан хаагч	Монгол Улсын төр, төрийн албан хаагчид эерэг, сөрөг ямар нэгэн нөлөө үзүүлэхээргүй байна.

### **1.3. Асуудлыг үүсгэж буй шалтгаан нөхцөлийг тогтоох:**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39<sup>1</sup> дүгээр зүйлийн 39<sup>1.2</sup> дахь хэсэгт иргэд тодорхой асуудлыг шийдвэрлүүлэх талаарх саналаа Улсын Их Хурлын албан ёсны санал авах цахим хуудсаар дамжуулан гаргаж болох, албан ёсоор санал авахаар байршуулснаас хойш 30 хоногийн хугацаанд хуулийн төслийн талаарх саналыг 100 мянга ба түүнээс дээш иргэд дэмжсэн бол саналыг хэлэлцэхээр заасан бөгөөд үүний дагуу 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр цахим системд тавигдах өргөдлийн шаардлага хангасан иргэн Н.Номун-Эрдэнийн “Газрыг гадаадын иргэн 100 жилээр ашиглах, эзэмшихийг цуцлах” сэдэвтэй, “Хуулийн төсөл санаачлах талаар санал гаргах” ангиллаар нийтлүүлсэн хүсэлт 100167 иргэний дэмжлэг авсан.

Холбогдох эрх зүйн зохицуулалтаас үзэхэд Монгол Улсын Үндсэн хууль, Газрын тухай хуультай хууль хоорондын зөрчил үүсгэж байна.

## **ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ**

Энэхүү үнэлгээний тайлангийн Нэгд заасан асуудлыг шийдвэрлэх хэрэгцээ, шаардлага урган гарч байгаатай холбогдуулан Аргачлалын 4-т заасны дагуу асуудлыг шийдвэрлэх ерөнхий зорилгыг дараах байдлаар тодорхойлж байна.

### **Зорилго:**

Хууль хоорондын зөрчлийг арилгах, иргэд, олон нийтийн сонгож байгуулсан төрийн эрх барих дээд байгууллагын үйл хэрэгт иргэдийн оролцоог хангаж хуулийн төслийг боловсруулах.

## **ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ЭЭРЭГ, СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ**

### **3.1. Хууль тогтоомжийн төсөл боловсруулах:**

Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдлэхдээ тодорхой асуудлыг шийдвэрлүүлэх талаар санал гаргах өгөх эрхээ баталгаажуулж “Газрыг гадаадын иргэн 100 жилээр ашиглах, эзэмшихийг цуцлах” сэдэвтэй, “Хуулийн төсөл санаачлах талаар санал гаргах” ангиллаар нийтлүүлсэн хүсэлт 100167 иргэний

дэмжлэг авсны дагуу Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах шаардлагатай байна.

## **ДӨРӨВ.ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ**

Аргачлалын 5.4-т заасны дагуу “хуулийн төсөл боловсруулах” нэг хувилбарыг шууд сонгосон ба үүнтэй холбогдуулан сонгосон нэг хувилбарын үр нөлөөг Аргачлалын 6-д заасны дагуу ерөнхий асуултуудад хариулах замаар дүгнэлтийг нэгтгэн гаргалаа.

*Жич: Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг шалгуур асуултын дагуу тандсан байдлыг үнэлгээний тайланд хавсаргасан хавсралт хүснэгт 1, 2, 3, 4-өөс үзнэ үү.*

### **4.1.Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө**

Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид газар ашиглуулахгүй байх зохицуулалтыг Газрын тухай, Ашигт малтмалын тухай болон холбогдох бусад хуулиудад оруулах тохиолдолд гадаад, дотоодын хөрөнгө оруулагчийг ялгаварласан, эрх зүйн байдлыг дордуулсан үндэслэлээр Монгол Улсын олон улсын гэрээ, Монгол Улсын Үндсэн хуулийн зарим заалтыг хөндөж болзошгүй байна.

### **4.2.Эдийн засагт үзүүлэх үр нөлөө**

Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид газар ашиглуулахтай холбоотой хуулийн зохицуулалтыг хүчингүй болгох тохиолдолд Газрын тухай, Ашигт малтмалын тухай хуулийн дагуу газар ашиглаж байсан гадаадын хөрөнгө оруулагчтай байгуулсан гэрээ, тусгай зөвшөөрлийн хугацаа дуусмагц тухайн газар дээрх барилга байгууламж, бусад эд хөрөнгийг тухайн газар дээр ашиглах эрх мөн дуусгавар болох тул өмчлөгч нь гэрээнд заасны дагуу арга хэмжээ авах, эсхүл шүүх арбитра хандах эрсдэлтэй.

### **4.3.Нийгэмд үзүүлэх үр нөлөө**

“Хуулийн төсөл боловсруулах” хувилбарын хувьд Аргачлалын 6.2-т заасан нийгэмд үзүүлэх үр нөлөөний суурь асуултын хариулт /Хавсралт хүснэгт 3/-аас харахад нийгэмд үзүүлэх ямар нэг сөрөг үр нөлөө байхгүй ба төрийн байгууллага хуулиар хүлээсэн тусгайлсан чиг үүргээ хэрэгжүүлэх боломж сайжирч, төрийн албан хаагчдын хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд болон төрийн үйлчилгээний чанар, хүртээмжид эерэгээр нөлөөлөхөөр байна.

### **4.4.Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө**

Аргачлалын 6.2-т заасан байгаль орчинд үзүүлэх үр нөлөөний суурь асуултын хариулт /Хавсралт хүснэгт 4/-аас харахад “хуулийн төсөл боловсруулах” хувилбар байгаль орчинд ямар нэгэн шууд болон шууд бус сөрөг нөлөө үзүүлэхгүй.

### **4.5.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж байгаа эсэх**

“Хуулийн төсөл боловсруулах” хувилбар нь Монгол Улсын Үндсэн хууль болон хүчин төгөлдөр үйлчилж байгаа бусад хууль тогтоомжийг аливаа хэлбэрээр зөрчөөгүй хэмээн дүгнэж байна.

### **ТАВ.ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫГ ХАРЬЦУУЛСАН ДҮГНЭЛТ**

Аргачлалын 7-д зааснаар хувилбаруудын эерэг болон сөрөг талуудыг

- Зорилгод хүрэх байдал;
- Зардал, үр өгөөжийн харьцаа;
- Хүний эрх, эдийн засагт, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө;
- Хууль тогтоомжтой нийцэж буй эсэх;
- Гарч болох сөрөг үр дагавар, түүнийг арилгах хувилбар байгаа эсэх

гэсэн шалгуураар дахин нягтлан үзэж, дүгнэлт гаргахаар заасан боловч Аргачлалын 5.4.2-т “тухайн асуудлыг гагцхүү хуулиар зохицуулах шаардлагатай болохыг Үндсэн хуульд онцлон заасан бол” гэж заасны дагуу “хууль тогтоомжийн төсөл боловсруулах” гэсэн ганц хувилбарыг шууд сонгосон байна.

Иймд Аргачлалын 7.1-д заасны дагуу зохицуулалтын хувилбар тус бүрийн эерэг болон сөрөг үр нөлөөг хооронд нь харьцуулж дүгнэх хэсгийг хийх шаардлагагүй байна.

### **ЗУРГАА.ЗӨВЛӨМЖ**

Энэ хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх ажлын явцад гарсан дараах асуудлыг анхаарч, хуулийн төслийг боловсронгуй болгох, чанарыг сайжруулах чиглэлээр өөрчлөлт оруулах нь зүйтэй гэсэн дараах зөвлөмжийг боловсрууллаа. Үүнд:

1.Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид газар ашиглуулахгүй байх зохицуулалтыг Газрын тухай, Ашигт малтмалын тухай, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай болон холбогдох бусад хуулиудад оруулах тохиолдолд гадаад, дотоодын хөрөнгө оруулагчийг ялгаварласан, эрх зүйн байдлыг дордуулсан үндэслэлээр Монгол Улсын олон улсын гэрээ, Монгол Улсын Үндсэн хуулийн зарим заалтыг хөндөж болзошгүй байна;

2.Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид газар ашиглуулахтай холбоотой хуулийн зохицуулалтыг хүчингүй болгох тохиолдолд Газрын тухай, Ашигт малтмалын тухай хуулийн дагуу газар ашиглаж байсан гадаадын хөрөнгө оруулагчтай байгуулсан гэрээ, тусгай зөвшөөрлийн хугацаа дуусмагц тухайн газар дээрх барилга байгууламж, бусад эд хөрөнгийг тухайн газар дээр ашиглах эрх мөн дуусгавар болох тул өмчлөгч нь гэрээнд заасны дагуу арга хэмжээ авах, эсхүл шүүх арбитрад хандах боломжтой болно;

3.Гадаадын хөрөнгө оруулагчид газар ашиглуулахгүй болох нь хууль зүйн болон эдийн засгийн зарим сөрөг үр дагавар үүсгэж болзошгүй байх тул гадаадын хөрөнгө оруулагчид зөвхөн Засгийн газрын шийдвэрээр тодорхой нөхцөл, болзолтойгоор газар

ашиглуулах, ашиглуулах гэрээний хэрэгжилтэд хяналт сайн тавих, хэрэв гэрээний үүргээ биелүүлээгүй бол гэрээг хугацаанаас нь өмнө цуцалдаг байх, газар ашиглуулах гэрээний ерөнхий хугацааг Хөрөнгө оруулалтын тухай хуульд зааснаас богиносгох нь зүйтэй гэж үзэж байна.

---oOo---

## Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөний үнэлгээ

Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах үнэлгээний тайлангийн хавсралт 1

### ХҮНИЙ ЭРХЭД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ (Хүснэгт 1)

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1. Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж буй эсэх	<b>1.1. Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх</b>			
	1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Тийм	Үгүй	ялгаварлан гадуурхах зохицуулалт тусаагүй
	1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй	ялгаварлан гадуурхах зохицуулалт тусаагүй
	1.1.3.Энэ нь тодорхой бүлгийн эмзэг байдлыг дээрдүүлэхийн тулд авч буй түр тусгай арга хэмжээ мөн бол олон улсын болон үндэсний хүний эрхийн хэм хэмжээнд нийцэж буй эсэх	Тийм	Үгүй	
	<b>1.2. Оролцоог хангах</b>			
	1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцоо боломжийг бүрдүүлсэн эсэх	Тийм	Үгүй	Аргачлалд заасны дагуу шууд хуулийн төсөл боловсруулах хувилбарыг сонгосон.
	1.2.2.Ялангуяа зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Аргачлалд заасны дагуу шууд хуулийн төсөл боловсруулах хувилбарыг сонгосон.
	<b>1.3. Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал хариуцлага</b>			
	1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхүүлэн дэмжих,	Тийм	Үгүй	Иргэд, олон нийтийн сонгож байгуулсан төрийн эрх барих дээд байгууллагын үйл хэрэгт иргэдийн оролцоог хангасан

	хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх			
	1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, НҮБ-ын хүний эрхийн механизмаас тухайн асуудлаар өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	
	1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх	Тийм	Үгүй	Шаардлагагүй
2. Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1. Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах бол энэ нь хууль ёсны зорилгод нийцсэн эсэх	Тийм	Үгүй	Энэ хуулиар хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлын эсрэг зохицуулалт тусахгүй.
	2.2. Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх	Тийм	Үгүй	Шаардлагагүй
3. Эрх агуулагч	3.1.Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Хуулийн үйлчлэлд иргэд, хуулийн этгээд, төрийн байгууллага хамаарна.
	3.2. Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Үгүй
	3.3.Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх	Тийм	Үгүй	Хуулийн төсөл боловсруулах хувилбарын хүрээнд хязгаарласан зохицуулалт хуулийн төсөлд тусгагдахгүй.
	3.4.Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх /хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй/	Тийм	Үгүй	Хуулийн төсөл боловсруулах хувилбарын хүрээнд хязгаарласан зохицуулалт хуулийн төсөлд тусгагдахгүй.
Үүрэг хүлээгч	4.1.Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Хуулийн төсөл боловсруулах хувилбарын хүрээнд зохицуулна.
4. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд	5.1.Жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	Тийм	Үгүй	Хуулийн төсөл боловсруулах хувилбарын хүрээнд хүйсээр ялгаварлах асуудал тусгагдахгүй.

нийцүүлсэн эсэх	5.2.Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Хуулийн төсөл боловсруулах хувилбарын хүрээнд Үндсэн хуульд заасан тэгш эрх, шударга ёсны зарчимд нийцүүлнэ.
--------------------	---	------	------	--

---oOo---

Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах үнэлгээний тайлангийн хавсралт 2

**ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ**  
(Хүснэгт 2)

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Зарим сөрөг нөлөө үүсэж болно
	1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4.Мэдээлэх үүргийн улмаас үүсч байгаа захиргааны зардлын ачаалал	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
5.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
6.Инноваци болон судалгаа шинжилгээ	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Гадаадын хөрөнгө оруулалтыг буцаан татсан тохиолдолд нөлөө үзүүлж болзошгүй

	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Гадаадын хөрөнгө оруулалтыг буцаан татсан тохиолдолд нөлөө үзүүлж болзошгүй
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
9.Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
10.Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Гадаадын хөрөнгө оруулалтыг буцаан татсан тохиолдолд нөлөө үзүүлж болзошгүй
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх	Тийм	Үгүй	Дотоодын хөрөнгө оруулагчдын тоо нэмэгдэх эерэг нөлөөтэй
	10.3.Инфляци нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
11.Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	Хуулийн төсөл боловсруулах хувилбарын хүрээнд Монгол Улсын олон улсын гэрээнд

				нийцүүлэх авагдана.	арга	хэмжээг
--	--	--	--	------------------------	------	---------

---oOo---

Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах үнэлгээний тайлангийн хавсралт 3

**НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ**  
(Хүснэгт 3)

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
		Тийм	Үгүй	
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэршээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Газар эзэмших, ашиглах гэрээ байгуулсан гадаадын хөрөнгө оруулагчдад нөлөө үзүүлж болно.

4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Одоо гэрээ байгуулсан хөрөнгө оруулагчдад нөлөөлж болзошгүй
	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
8.Соёл	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

—oOo—

Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах үнэлгээний тайлангийн хавсралт 4

**БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ**  
(Хүснэгт 4)

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Агаар	1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
2.Зам тээвэр, түлш, эрчим хүч	2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3.Ан амьтан, ургамлыг хамгаалах	3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.3.Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.4.Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4.Усны нөөц	4.1.Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.2.Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.3.Ундны усны чанарт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
5.Хөрсний бохирдол	5.1.Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	5.2.Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.

6.Газрын ашиглалт	6.1.Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	6.2.Газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	Одоо гэрээ байгуулсан хөрөнгө оруулагчдын гэрээг цуцалсан тохиолдолд
	6.3.Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
7.Нөхөн сэргээгдэх/нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1.Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхийг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	7.2.Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.

---oOo---

Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах үнэлгээний тайлангийн хавсралт 5

## **Ашигласан мэдээлэл, судалгаа, гарын авлага, хууль тогтоомжийн жагсаалт**

### **I.Хууль тогтоомж, эрх зүйн акт**

- Монгол Улсын Үндсэн хууль
- Хууль тогтоомжийн тухай хууль
- Газрын тухай хууль
- Ашигт малтмалын тухай хууль
- Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай

### **II.Засгийн газрын тогтоол**

- Монгол Улсын Засгийн газрын тогтоол, Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал 2016 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 59 дүгээр тогтоолын 1, 3, 4 дүгээр хавсралт

### **III. Интернет эх сурвалж**

- [www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn)
- <https://www.unuudur.mn>

---oOo---

# ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН ҮНЭЛГЭЭ

## НЭГ.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Энэхүү үнэлгээний ажлын гол зорилго нь Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зохицуулалтад тодорхой шалгуур үзүүлэлтийн дагуу дүн шинжилгээ хийх, үр нөлөөг тооцож, давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хуулийн зохицуулалтыг ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулах, хуулийн төслийн чанарыг сайжруулахад оршино.

Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1-ийн хөрөнгө оруулагчид үзүүлэх татварын бус хөрөнгө оруулалтын дэмжлэгийн нэг хэлбэр болох “газрыг 60 хүртэл жилээр гэрээний үндсэн дээр эзэмшүүлэх, ашиглуулах, уг хугацааг гэрээний анхны нөхцөлөөр нэг удаа 40 хүртэл жилээр сунгах” асуудлыг зохицуулсан заалтыг хүчингүй болгохтой холбоотой хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хуульд нийцэх эсэх, үүсэх үр нөлөө, бусад хууль тогтоомжтой уялдаж байгаа эсэхийг хянан үзэв.

Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах үнэлгээний тайлангаас харахад Хөрөнгө оруулалтын тухай хуулийн Монгол Улсад хөрөнгө оруулагч гадаадын хуулийн этгээд, гадаадын иргэнд газрыг гэрээний үндсэн дээр 60 хүртэл жилээр эзэмшүүлэх, ашиглуулах, уг хугацааг 40 хүртэл хүртэл жилээр сунгах, нийт 100 хүртэлх жилийн хугацаагаар эзэмшүүлж, ашиглуулах зохицуулалт нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан гадаадын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүнд газрыг тодорхой болзол, журмын дагуу ашиглуулж болно гэсэн заалттай зөрчилдөж байгаа тул хууль хоорондын зөрчлийг арилгах зорилгоор хуулийн төслийг боловсруулжээ.

Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /цаашид “хуулийн төсөл” гэх/-ийн зохицуулалтын үр нөлөөг үнэлэхдээ Хууль тогтоомжийн тухай хууль, “Хуулийн төслийн үр нөлөө үнэлэх аргачлал”<sup>1</sup> /цаашид “Аргачлал” гэх/-д заасны дагуу дараах үе шаттайгаар хийлээ:

- 1.1.Шалгуур үзүүлэлтийг сонгох;
- 1.2.Хуулийн төслөөс үр нөлөө үнэлэх хэсгээ тогтоох;
- 1.3.Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
- 1.4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

---

<sup>1</sup> Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.1-д заасны дагуу 2016 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн Монгол Улсын Засгийн газрын 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан.

## ХОЁР.ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ

Тус үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан Аргачлалд дурдсан нийт 6 шалгуур үзүүлэлтээс дараах 3 шалгуур үзүүлэлтийг сонголоо. Үүнд:

- 2.1.Зорилгод хүрэх байдал
- 2.2.Зардал
- 2.2.Харилцан уялдаа.

Дээрх шалгуур үзүүлэлтийг тухайлан сонгох болсон үндэслэл нь хуулийн төслийн зүйл, заалтад тодорхой шалгуур үзүүлэлтийн дагуу дүн шинжилгээ хийх, үр нөлөөг тооцож, давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, үндсэн зорилго, зохицуулах харилцааны онцлогт нийцүүлэх, улмаар хуулийн төслийн чанарыг сайжруулахад оршино.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39<sup>1</sup> дүгээр зүйлийн 39<sup>1.2</sup> дахь хэсэгт иргэд тодорхой асуудлыг шийдвэрлүүлэх талаарх саналаа Улсын Их Хурлын албан ёсны санал авах цахим хуудсаар дамжуулан гаргаж болох, 39<sup>1.2.3</sup> дахь заалтад хуулийн төслийн талаарх саналыг 100 мянга ба түүнээс дээш иргэд дэмжсэн бол саналыг хэлэлцэхээр заасан бөгөөд иргэд, олон нийтийн сонгож байгуулсан төрийн эрх барих дээд байгууллагын үйл хэрэгт иргэдийн идэвх, оролцоог хангах шаардлага үүссэн тул Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсныг хуулийн төслийн үзэл баримтлалд дурджээ.

Иймд хуулийн төслийн үзэл баримтлалаар дэвшүүлсэн зорилтын хүрээнд хуулийн төсөлд өөрчлөхөөр тусгасан зохицуулалт нь үзэл баримтлалын зорилтыг хангасан эсэхийг тогтоох, иргэн, хуулийн этгээд, улсын төсөвт ачаалал үүсэх эсэх, эдгээр зохицуулалт харилцан уялдаа бүхий бусад хуультай уялдсан эсэхэд дүн шинжилгээ хийх зорилгоор дээр дурдсан 3 шалгуур үзүүлэлтийг сонголоо.

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн үзэл баримтлалд дурдсан хууль хоорондын зөрчлийг арилгах, иргэд, олон нийтийн сонгож байгуулсан төрийн эрх барих дээд байгууллагын үйл хэрэгт иргэдийн оролцоог хангах үндсэн зорилгод нийцсэн эсэх асуудлыг судалж, тодорхойлохыг зорьсон.

“Зардлын тооцоо” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн хөрөнгө оруулагчид үзүүлэх татварын бус хөрөнгө оруулалтын дэмжлэгт газрыг 60 хүртэл жилээр гэрээний үндсэн дээр эзэмшүүлэх, ашиглуулах, уг хугацааг гэрээний анхны нөхцөлөөр нэг удаа 40 хүртэл жилээр сунгах зохицуулалтыг хуулиас хасах нь иргэн, хуулийн этгээд, улсын төсөвт ачаалал үүсгэх эсэх асуудлыг тодруулахаар сонгов.

“Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг бүхэлд нь сонгож, хуулийн төслийн 2 зүйл өөр хоорондоо болон Монгол Улсын Үндсэн хууль, холбогдох бусад хуульд нийцсэн эсэх, бусад байгууллагын чиг үүрэгтэй давхардсан,

зөрчилдсөн эсэх, уг чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх боломжтой эсэхийг Аргачлалд заасан асуултад хариулах замаар шалгах аар сонгов.

### **ГУРАВ.ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ**

Аргачлалд заасны дагуу хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгосон тул түүнд хамаарах үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоохдоо хуулийн төслийн үзэл баримтлалд үндэслэн хуулийн төслийн зохицуулалт бүхэлдээ чухал ач холбогдолтойг харгалзан хуулийн төслийг бүхэлд нь шалгуур үзүүлэлтийн хүрээнд нь сонголоо:

<b>Д/д</b>	<b>Шалгуур үзүүлэлт</b>	<b>Үр нөлөөг үнэлэх хэсэг</b>
3.1	<b>Зорилгод хүрэх байдал</b>	Хуулийн төсөл бүхэлдээ
3.2	<b>Зардлын тооцоо</b>	Хуулийн төсөл бүхэлдээ
3.3	<b>Харилцан уялдаа</b>	Хуулийн төсөл бүхэлдээ

### **ДӨРӨВ.ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ**

Аргачлалд заасны дагуу хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлт, үр нөлөөг үнэлэх хэсгийг тус тус тогтоож, тэдгээрт тохирох шалгах хэрэгслийг дараах байдлаар тодорхойллоо:

<b>Д/д</b>	<b>Шалгуур үзүүлэлт</b>	<b>Үр нөлөөг үнэлэх хэсэг</b>	<b>Тохирох шалгах хэрэгсэл</b>
4.1	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төсөл бүхэлдээ	<b>Зорилгод дүн шинжилгээ хийх:</b> Хуулийн төслийн зохицуулалт нь төслийн үзэл баримтлалд дурдсан зорилгод нийцсэн эсэхэд дүн шинжилгээ хийнэ.
4.2.	Зардал	Хуулийн төсөл бүхэлдээ	<b>Зардлын тооцоо хийх</b> Хуулийн төслийн зохицуулалт иргэн, хуулийн этгээд, улсын төсөвт ачаалал үүсгэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийнэ.
4.3.	Харилцан уялдаа	Хуулийн төсөл бүхэлдээ	<b>Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах:</b> Хуулийн төслийн уялдаа холбоог Аргачлалын 4.10-т заасан асуултад хариулах замаар шалгана.

#### **4.1 Шалгуур үзүүлэлт: Зорилгод хүрэх байдал**

“Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг бүхэлд нь сонгосон бөгөөд бодит байдал дээр хуулийн төслийн үзэл баримтлалд заасан хууль хоорондын зөрчлийг арилгах, иргэд, олон нийтийн сонгож байгуулсан төрийн эрх барих дээд байгууллагын үйл хэрэгт иргэдийн оролцоог хангах үндсэн зорилгод нийцсэн эсэх асуудлыг судалж, тодорхойлохыг зорьсон.

Хуулийн төслийн үзэл баримтлалд хуулийн төслөөр зохицуулах асуудлыг дараах байдлаар тусгажээ:

- хууль хоорондын зөрчлийг арилгах;

- иргэд, олон нийтийн сонгож байгуулсан төрийн эрх барих дээд байгууллагын үйл хэрэгт иргэдийн оролцоог хангах.

Иймд дээрх асуудлыг шийдвэрлэхэд анхаарлаа хандуулах зайлшгүй шаардлагатай ба энэ зорилтыг хангахын тулд холбогдох зохицуулалтыг хуулийн төсөлд дараах байдлаар тусгасан байна:

Хүснэгт 1

**Хуулийн төслөөс:**

**“1 дүгээр зүйл.**Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсгийн “Газрын тухай<sup>7</sup>,” гэснийг хассугай.

**2 дугаар зүйл.**Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх заалтыг хүчингүй болсонд тооцугай.

Монгол Улсын Үндсэн хууль, Газрын тухай хуульд гадаад улс, олон улсын байгууллага, гадаадын хуулийн этгээд, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид газрыг ашиглуулах асуудлыг дараах байдлаар тусгажээ:

Хүснэгт 2

**Монгол Улсын Үндсэн хуулиас:**

**Зургадугаар зүйл**

5.Төрөөс гадаадын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүнд газрыг төлбөр, хугацаатайгаар болон хуульд заасан бусад болзол, журмаар ашиглуулж болно.

**Газрын тухай хуулиас:**

**17 дугаар зүйл.**Улсын Их Хурлын бүрэн эрх

17.1. Улсын Их Хурал газрын харилцааны талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

17.1.1. газрын талаар төрөөс явуулах нэгдсэн бодлогыг тодорхойлох;

17.1.2. гадаад улс, олон улсын байгууллага, гадаадын хуулийн этгээдэд газрыг тодорхой хугацаагаар түрээс, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээгээр ашиглуулах талаар шийдвэр гаргах;

### **18 дугаар зүйл. Засгийн газрын бүрэн эрх**

18.1. Засгийн газар газрын харилцааны талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

18.1.6. энэ хуулийн 17.1.2-т заасан газрын зааг, ашиглах журмыг тогтоох;

### **44 дүгээр зүйл. Газар ашиглуулах**

44.5. Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид энэ хуулийн дагуу газрыг тусгай зориулалт, хугацаа, болзолтойгоор ашиглуулах бөгөөд уг хугацааг Засгийн газар тогтооно.

Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 12 дугаар зүйлд гадаадын хөрөнгө оруулагчид үзүүлэх татварын бус хөрөнгө оруулалтын дэмжлэгийг дараах байдлаар тусгасан:

Хүснэгт 3

#### **Хөрөнгө оруулалтын тухай хуулиас:**

### **12 дугаар зүйл. Татварын бус хөрөнгө оруулалтын дэмжлэг**

12.1. Хөрөнгө оруулагчид татварын бус хөрөнгө оруулалтын дэмжлэгийг дараах хэлбэрээр үзүүлж болно:

12.1.1. газрыг 60 хүртэл жилээр гэрээний үндсэн дээр эзэмшүүлэх, ашиглуулах, уг хугацааг гэрээний анхны нөхцөлөөр нэг удаа 40 хүртэл жилээр сунгах;

12.2. Татварын бус хөрөнгө оруулалтын дэмжлэгийг Газрын тухай<sup>2</sup>, Чөлөөт бүсийн тухай<sup>3</sup>, Үйлдвэрлэл технологийн паркийн эрх зүйн байдлын тухай,<sup>4</sup> Инновацийн тухай,<sup>5</sup> Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна.

Дээр дурдсан зохицуулалтаас харахад Монгол Улсын Үндсэн хуулиар төрөөс гадаадын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүнд газрыг төлбөр, хугацаатайгаар болон хуульд заасан бусад болзол, журмын дагуу ашиглуулж болохоор, Газрын тухай хуулиар гадаад улс, олон улсын байгууллага, гадаадын хуулийн этгээдэд газрыг тодорхой хугацаагаар түрээс, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээгээр ашиглуулах

<sup>2</sup> Газрын тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2002 оны 27 дугаарт нийтлэгдсэн.

<sup>3</sup> Чөлөөт бүсийн тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2002 оны 27 дугаарт нийтлэгдсэн.

<sup>4</sup> Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2010 оны 02 дугаарт нийтлэгдсэн.

<sup>5</sup> Инновацийн тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2012 оны 24 дугаарт нийтлэгдсэн.

талаар Улсын Их Хурал шийдвэр гаргахаар, уг газрын зааг, ашиглах журмыг Засгийн газар тогтоохоор, мөн гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид газрыг тусгай зориулалт, хугацаа, болзолтойгоор ашиглуулах бөгөөд уг хугацааг Засгийн газар тогтоохоор тус тус заасан.

Гэсэн хэдий ч 2013 онд баталсан Хөрөнгө оруулалтын тухай хуулиар хөрөнгө оруулагчид үзүүлэх татварын бус хөрөнгө оруулалтын дэмжлэгээр газрыг гэрээний үндсэн дээр 60 хүртэл жилээр, уг хугацааг гэрээний анхны нөхцөлөөр нэг удаа 40 хүртэл жилээр сунгах, нийт 100 хүртэлх жилийн хугацаагаар эзэмшүүлж, ашиглуулах нөхцөл бүрдэж байгаа нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан гадаадын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүнд газрыг тодорхой болзол, журмын дагуу ашиглуулж болно гэсэн заалттай зөрчилдөж байна.

Иймд хуулийн төслөөр Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 12.1.1 дэх заалт буюу гадаадын хөрөнгө оруулагчид үзүүлэх татварын бус дэмжлэгийн нэг хэлбэр болох газар эзэмшүүлэх, ашиглуулах зохицуулалтыг хүчингүй болгосноор гадаадын хөрөнгө оруулалт татах, гадаадын иргэн, хуулийн этгээд, аж ахуйн нэгжийн эрх ашиг хөндөгдөх асуудал гарахгүй бөгөөд хөрөнгө оруулагчдын газар эзэмших, ашиглах асуудлыг Газрын тухай, Ашигт малтмалын тухай, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн дагуу зохицуулах боломжтой байна.

Мөн Газрын тухай, Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах үндэслэл шаардлага үүсэхгүй бөгөөд эдгээр хуулийн дагуу олгосон газар ашиглах эрх/зөвшөөрөл/ хүчинтэй хэвээр байх тул хөрөнгө оруулагчид нийгэм, эдийн засгийн талаас ямар нэгэн эрсдэл үүсэхгүйгээр хуулийн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломжтой байна.

Монгол Улсын Их Хурлаас 2022 оны 07 дугаар сарын 05-ны өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулиар цахим парламентын үйл ажиллагааг нэвтрүүлэх, Улсын Их Хурлын шинэчлэлийн зорилтын хүрээнд Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдлэхдээ тодорхой асуудлыг шийдвэрлүүлэх талаар санал өгөх эрхийг баталгаажуулсан.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39<sup>1</sup> дүгээр зүйлийн 39<sup>1.2</sup> дахь хэсэгт иргэд тодорхой асуудлыг шийдвэрлүүлэх талаарх саналаа Улсын Их Хурлын албан ёсны санал авах цахим хуудсаар дамжуулан гаргаж болох, албан ёсоор санал авахаар байршуулснаас хойш 30 хоногийн хугацаанд хуулийн төслийн талаарх саналыг 100 мянга ба түүнээс дээш иргэд дэмжсэн бол саналыг хэлэлцэхээр заасан бөгөөд үүний дагуу 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр цахим системд тавигдах өргөдлийн шаардлага хангасан иргэн Н.Номун-Эрдэнийн "Газрыг гадаадын иргэн 100 жилээр ашиглах, эзэмшихийг цуцлах" сэдэвтэй, "Хуулийн төсөл санаачлах талаар санал гаргах" ангиллаар нийтлүүлсэн хүсэлт 100167 иргэний дэмжлэг авсан байна.

Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан хуулийн төсөл батлагдсанаар цаашид Улсын Их Хурлын санал авах

цахим системээр иргэдийн саналаа өгөх идэвх нэмэгдэх, төрийн үйл хэрэгт иргэдийн оролцох оролцоо сайжрах тул “Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлт бүрэн хангагдана гэж үзэж байна.

#### 4.2.Шалгуур үзүүлэлт: Зардлын тооцоо

Хуулийн төсөл батлагдсанаар уг хуулийг хэрэгжүүлэх иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад үүсэх зардал, ачааллыг тооцох зорилгоор хуулийн төслөөс иргэн, хуулийн этгээдийн гүйцэтгэх үүрэг, төрийн байгууллагын чиг үүргийг тодорхойлоход хуулийн төсөлд иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад үүрэг хүлээлгэх зохицуулалт тусгагдаагүй тул цаашид зардал үүсгэх эсэхийг тооцоолох шаардлагагүй бөгөөд улсын төсөвт ачаалал үүсгэхгүй гэж үзсэн.

#### 4.3.Шалгуур үзүүлэлт: Хуулийн төслийн уялдаа холбоо

Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн дотоод болон бусад хуультай уялдах уялдаа холбоог сайжруулах, хууль тогтоомжийн давхардал, хийдэл, зөрчлийг тогтоох зорилгоор Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-ын 4.10-т заасан заасан шалгуурт нийцүүлэн боловсруулсан асуултад хариулах байдлаар шалгаж үнэллээ.

Хүснэгт 3

Д/д	Асуултууд	Хариулт
1	Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх;	Тийм
2	Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томьёо тухайн хуулийн төслийн болон бусад хууль тогтоомжийн нэр томьёотой нийцэж байгаа эсэх;	Тийм
3	Хуулийн төслийн хэсэг, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хууль тогтоомжийн заалттай нийцэж байгаа эсэх;	Тийм
4	Хуулийн төслийн зүйл тухайн хуулийн төслийн болон бусад хууль тогтоомжийн заалттай давхардсан эсэх;	Үгүй
6	Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх;	Шаардлагагүй
7	Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх;	Үгүй
8	Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх;	Үгүй
9	Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх;	Шаардлагагүй
10	Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх;	Үгүй

11	Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх;	Шаардлагагүй
12	Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх;	Үгүй
13	Хуулийн төслийн хэсэг, заалт жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх;	Тийм
14	Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Үгүй
15	Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Үгүй
16	Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.	Шаардлагагүй

Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд Аргачлалын 4.10-т заасан шалгуурт нийцүүлэн боловсруулсан асуултад хариулах байдлаар хуулийн төслийн үр нөлөөг үнэлсэн бөгөөд хуулийн төслийн зохицуулалт өөр хоорондоо болон бусад хууль тогтоомжтой зөрчилдөөгүй байна.

## **ТАВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГӨХ**

Үр дүнг үнэлж, зөвлөмж өгөх үе шатыг Аргачлалын 5-д заасны дагуу дараах дарааллаар хийлээ:

- 5.1.үнэлэх;
- 5.2.зөвлөмж өгөх.

### **5.1.Үнэлэх:**

Хуулийн төсөл нь үзэл баримтлалд дэвшүүлсэн зорилгоо хангасан эсэх, зардал үүсгэх эсэх, бусад хуультай хэрхэн уялдсан гэсэн шалгуур үзүүлэлт тус бүрийн дагуу хийсэн үнэлэлтийг нэгтгэн дараах дүгнэлтийг хийж, зөвлөмж боловсрууллаа.

### **5.2.Дүгнэлт:**

Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх ажиллагааг хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх 3 шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн ба шалгуур үзүүлэлт тус бүрээр дүгнэвэл:

**Зорилгод хүрэх байдал:** Хуулийн төслөөр Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 12.1.1 дэх заалт буюу гадаадын хөрөнгө оруулагчид үзүүлэх татварын бус дэмжлэгийн нэг хэлбэр болох газар эзэмшүүлэх, ашиглуулах зохицуулалтыг хүчингүй болгосноор гадаадын хөрөнгө оруулалтыг буцаан татах, гадаадын иргэн, хуулийн этгээд, аж ахуйн нэгжийн эрх ашиг хөндөгдөх асуудал гарахгүй бөгөөд хөрөнгө оруулагчдын газар

эзэмших, ашиглах асуудлыг Газрын тухай, Ашигт малтмалын тухай, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн дагуу зохицуулах боломжтой тул хуулийн төслийн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломжтой гэж үзэж байна.

**Зардал:** Хуулийн төсөл батлагдсанаар уг хуулийг хэрэгжүүлэх иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад үүсэх зардал, ачааллыг тооцох зорилгоор хуулийн төслөөс иргэн, хуулийн этгээдийн гүйцэтгэх үүрэг, төрийн байгууллагын чиг үүргийг тодорхойлоход хуулийн төсөлд иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад үүрэг хүлээлгэх зохицуулалт тусгагдаагүй тул цаашид зардал үүсгэх эсэхийг тооцоолох шаардлагагүй бөгөөд улсын төсөвт ачаалал үүсгэхгүй гэж үзсэн.

**Харилцан уялдааг хангасан байдал:** Хуулийн төслийг харилцан уялдаа гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд бүхэлд нь Аргачлалд заасан асуултад хариулах байдлаар хуулийн төслийн үр нөлөөг үнэлсэн бөгөөд хуулийн төслийн зохицуулалт өөр хоорондоо болон бусад хууль тогтоомжтой зөрчилдөөгүй байна.

### **5.3.Зөвлөмж:**

Энэ хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх ажлын явцад гарсан дараах асуудлыг анхаарч, хуулийн төслийг боловсронгуй болгох, чанарыг сайжруулах чиглэлээр өөрчлөлт оруулах нь зүйтэй гэсэн зөвлөмжийг хууль санаачлагчид өгч байна:

- ✓ Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид газар ашиглуулахгүй байх зохицуулалтыг Газрын тухай, Ашигт малтмалын тухай, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай болон холбогдох бусад хуулиудад оруулах тохиолдолд гадаад, дотоодын хөрөнгө оруулагчийг ялгаварласан, эрх зүйн байдлыг дордуулсан үндэслэлээр Монгол Улсын олон улсын гэрээ, Монгол Улсын Үндсэн хуулийн зарим заалтыг хөндөж болзошгүй байна;
- ✓ Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид газар ашиглуулахтай холбоотой хуулийн зохицуулалтыг хүчингүй болгох тохиолдолд Газрын тухай, Ашигт малтмалын тухай хуулийн дагуу газар ашиглаж байсан гадаадын хөрөнгө оруулагчтай байгуулсан гэрээ, тусгай зөвшөөрлийн хугацаа дуусмагц тухайн газар дээрх барилга байгууламж, бусад эд хөрөнгийг тухайн газар дээр ашиглах эрх мөн дуусгавар болох тул өмчлөгч нь гэрээнд заасны дагуу арга хэмжээ авах, эсхүл шүүх арбитрт хандах боломжтой болно;
- ✓ Гадаадын хөрөнгө оруулагчид газар ашиглуулахгүй болох нь хууль зүйн болон эдийн засгийн зарим сөрөг үр дагавар үүсгэж болзошгүй байх тул гадаадын хөрөнгө оруулагчид зөвхөн Засгийн газрын шийдвэрээр тодорхой нөхцөл, болзолтойгоор газар ашиглуулах, ашиглуулах гэрээний хэрэгжилтэд хяналт сайн тавих, хэрэв гэрээний үүргээ биелүүлээгүй бол гэрээг хугацаанаас нь өмнө цуцалдаг байх, газар ашиглуулах гэрээний ерөнхий хугацааг Хөрөнгө оруулалтын тухай хуульд зааснаас богиносгох нь зүйтэй гэж үзэж байна.

## АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

### I.Хууль тогтоомж, эрх зүйн акт

- Монгол Улсын Үндсэн хууль
- Хууль тогтоомжийн тухай хууль
- Газрын тухай хууль
- Ашигт малтмалын тухай хууль
- Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай

### II.Засгийн газрын тогтоол

- Монгол Улсын Засгийн газрын тогтоол, Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал 2016 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 59 дүгээр тогтоолын 1, 3, 4 дүгээр хавсралт

### III. Интернэт эх сурвалж

- [www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn)
- <https://www.unuudur.mn>
-

## **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН**

Хууль тогтоомжийн тухай хуулийн<sup>1</sup> 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу тодорхойлно.” гэж заасны дагуу Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /цаашид “хуулийн төсөл” гэх/ батлагдсанаар уг хуулийн үйлчлэх хүрээнд хамаарах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлыг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал” /цаашид “Аргачлал” гэх/-ын дагуу тооцлоо.

Аргачлалд заасны дагуу хуулийн төсөл батлагдсанаар уг хуулийг хэрэгжүүлэх иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад үүсэх зардал, ачааллыг тооцох зорилгоор хуулийн төслөөс иргэн, хуулийн этгээдийн гүйцэтгэх үүрэг, төрийн байгууллагын чиг үүргийг тодорхойлоход хуулийн төсөлд иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад үүрэг хүлээлгэх зохицуулалт тусгагдаагүй байна.

Иймээс уг хуулийн төсөл батлагдсанаар цаашид зардал үүсгэх эсэхийг тооцоолох шаардлагагүй бөгөөд улсын төсөвт ачаалал үүсгэхгүй гэж үзлээ.

---oOo---

---

<sup>1</sup> Хууль тогтоомжийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2015 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн 25 дугаарт нийтлэгдсэн.